



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.01 № 1/17 УАГ-САГ/2014/03-ТА-ТС

Арилжааны банкин дахь үлдэгдлийг  
төсөвт төвлөрүүлэх тухай


Зам тээврийн яамны хөрөнгө оруулалтын 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Худалдаа хөгжлийн банкинд нээсэн дансанд хандивын 6854 ам.доллар байршуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.11-д “банкинд данс нээх зөвшөөрлийг төсвийн байгууллагад олгох”, 35 дугаар зүйлийн 35.3-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих”, Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5-д “Банкинд төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур нээсэн төсвийн байгууллагын дансанд тухайн шатны төрийн сан болон төрийн аудитын байгууллага үзлэг, хяналт хийн, энэ хуулийн 35.3-т заасан зөвшөөрөлгүйгээр нээсэн дансыг хаалгах, хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд татан төвлөрүүлнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хандивын орлого 6854.00 (зургаан мянга найман зуун тавин дөрвөн ) ам.долларыг Төрийн сан банкин дахь Үндэсний аудитын газрын Төсвийн орлогын 900000601 тоот дансанд 2014 оны 4 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батзаяа, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга З.Цэрэнчимэг нарт хариуцуулав.

ТОГТООСОН: АКТЫГ

УАГ-ын Санхүүгийн аудитын газрын  
Ахлах аудитор  Ц.Гэрэл

УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:

Зам тээврийн яамны  
Төрийн нарийн бичгийн дарга  
Б.Батзаяа  
СХОХ-ийн дарга, ерөнхий нягтлан  
бодогч  З.Цэрэнчимэг

Уг данс нь 2014 оны данс нэмт ашигласан баасан болон  
УАГ-ын акттай дагуу 2014.04.16-нд Акт-Албан газартай 4 бланк